



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/271

Арвайхээр

**Захирамжийн зарим хэсгийг хүчингүй  
болгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.1дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2010 оны 213 дугаар захирамжийн 2 дугаарт байгаа иргэн Боржигон овогтой Шийлаагийн Баасан (ЙЮ74030811)-ийн Арвайхээр сумын 6 дугаар баг 43 дугаар гудамж 528 тоотод 759.16м<sup>2</sup> өмчилсөн газар нь бусдын эзэмшил, өмчлөлд олгогдсон газартай давхцсан тул иргэн Ш.Баасантай холбогдох заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулж, ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд), Арвайхээр сумын Засаг дарга (Б.Ганбат)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100586